



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, Байгууллагын 90 гаруй жилийн түүхэн үйл ажиллагаа, ахмад үеийн ажил, хөдөлмөрийн ололт амжилт, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлч, оновчтой үр дүн, тэдгээрт ашиглагдаж байсан техник тоног төхөөрөмжийн хөгжил, дэвшлийг хадгалан, шинэ үеийн мэргэжилтэн, албан хаагчиддаа таниулж, уламжлуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Зоонозын музей байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: У.Нармандах (Чанар, аюулгүй байдал, хяналт-үнэлгээний албаны дарга)

Гишүүд: У.Өнөрсайхан (Лавлагаа лабораторийн албаны дарга)

Д.Алтантогтох (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга)

С.Мөнхчимэг (Санхүү, хангамж, нөөцийн албаны Ерөнхий нягтлан бодогч)

И.Отгончимэг (Чанар, аюулгүй байдал, хяналт-үнэлгээний албаны Чанарын менежер)

Ц.Ганхуяг (Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Шимэгч судлагч)

Д.Батжав (Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Амьтан судлагч)

Э.Пагмадулам (Захиргааны албаны Хүний нөөцийн менежер)

Э.Дулмаа (Захиргааны албаны Хэвлэл мэдээлэл, маркетинг хариуцсан мэргэжилтэн)

О.Сансар (Санхүү, хангамж, нөөцийн албаны Аж ахуйн менежер)

Ч.Буянхишиг (Лавлагаа лабораторийн албаны Лаборант)

Б.Оргилтуул (Санхүү, хангамж, нөөцийн албаны Аж ахуйн нярав)

Ж.Эрдэнэбилэг (Чанар, аюулгүй байдал, хяналт-үнэлгээний албаны Лаборант)

2. Музейд байршуулах тоног төхөөрөмж, үзмэрийг хүлээлгэн өгөх ажлыг Албадын дарга нарт, гарах зардлын тооцоог батлуулан ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. “Зоонозын музей” байгуулах үйл ажиллагаанд гарах зардлыг холбогдох зардлаас гарган санхүүжүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР